

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-6

**1. “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын
хорооны тогтоолын төсөл** 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Баатархүү, О.Батнайрамдал, Ж.Баясгалан, Б.Бейсен, Х.Болормаа, А.Ганбаатар, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, Б.Түвшин, Г.Хосбаяр, Д.Энхтуяа.

Нэг. “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарыг нэр дэвшүүлж байгааг танилцуулав.

Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Найдалаа: Монгол Улсын Их Хурлын Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 2
Бүгд: 19
89.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа Соёл, спорт, залуучуудын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийг нэр дэвшүүлж байгааг танилцуулав.

Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Найдалаа: Монгол Улсын Их Хурлын Соёл, спорт, залуучуудын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 2
Бүгд: 19
89.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Найдалаа “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Найдалаа: “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 3
Бүгд: 19
84.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 63.3 хувийн ирцтэйгээр 15 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 45 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Найдалаа: Сайн байцгаана уу? Гишүүдийн өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 60 хувь буюу 18 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Ингээд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 7 сарын 9-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай, Шинэбаярын Бямбасүрэн, Мөнгөнцогийн Ганхүлэг, Бадрахын Найдалаа Мягмардашийн Сарнай, Лутаагийн Энхнасан, Аюушийн Ариунзаяа, Жанчивын Галбадрах, Сархадын Зулпхар Дүгэрийн Рэгдэл, Болдын Уянга, Мөнхчулууны Энхцэцэг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Отгоны Саранчулуун, Бадарчийн Хэрлэн, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэх байгаа.

1.Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны даргыг сонгох тухай асуудал.

2.Соёл, спорт, залуучуудын дэд хорооны даргыг сонгох тухай асуудал.

Хэлэлцэх асуудалтай холбоотой гишүүдээс саналтай гишүүн байна уу?

Саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Боловсрол, шинжлэх ухааны дэд хор дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Аюушийн Ариунзаяа гишүүн танилцуулна. Ариунзаяа гишүүнийг урьж байна.

А.Ариунзаяа: Өдрийн мэнд хүргэе та бүхэндээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны харьяа Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны даргад Сархадын Зулпхарыг дэвшүүлж байна.

Сархадын Зулпхар нь 1975 онд төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. 1993-98 онд Мимар синаны их сургууль, 98-99 онд МУИС, 2008 онд Удирдлагын академийг тус тус төгссөн.

1998-2003 онд Удирдлагын академид Философи, социологийн тэнхимийн багш, 2003-2009 онд Нийгмийн удирдлагын тэнхимд ахлах багш, 2009-12 онд Нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, 2012-16 онд Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, хөтөлбөрийн удирдагч, 2016-2020 онд Удирдлагын академийн захирал, 2020-24 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Дэд сайдаар ажилласан туршлагатай. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарын ажлын туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны харьяа Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүнд баярлалаа. Нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Үүнтэй холбоотой үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны даргад нэр дэвшигчийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтдаа бэлдье. Хуруугаа уншуулаарай. Санал хураалт.

Гишүүдийн 89.5 хувь буюу 17 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалд оръё.

Соёл, спорт, залуучуудын дэд хорооны даргад нэр дэвшигчийн нэр дэвшигчийг хэлэлцэж эхэлье.

Нэр дэвшигчийн асуудлыг хэлэлцэж эхэлье. Нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа гишүүн тавина. Ариунзаяа гишүүнийг урьж байна.

А.Ариунзаяа: Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны харьяа Соёл, спорт, залуучуудын дэд хорооны даргад Мөнгөнцогийн Ганхүлэгийг дэвшүүлж байна.

Мөнгөнцогийн Ганхөлөг нь 1990 онд Хэнтий аймагт төрсөн. Эхнэр 4 хүүхдийн хамтаар амьдардаг. 2008 онд Хэнтий аймаг Хан Хэнтий цогцолбор

сургууль, 2012 онд ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийг Бизнесийн удирдлага, маркетингийн менежерээр төгссөн.

2013-15 онд Шинэ дэлхий телевизийн Маркетинг, төлөвлөлтийн менежер, 2015 онд “Ашдын Түүчээ” компанийн гүйцэтгэх захирал, 2020-22 онд Социал Демократ Монголын Залуучуудын холбооны Бүс хариуцсан нарийн бичгийн дарга, 2020 оноос Хэнтий аймгийн ИТХ-ын төлөөлөгч, 2020-22 онд Монгол Ардын намын Улс төрийн бодлогын газрын дарга, 2022 оноос Хэнтий аймгийн Нутгийн зөвлөлийн гүйцэтгэх захирал, 2022 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2022 оноос Социал Демократ Монголын Оюутны холбооны Ерөнхийлөгч, 2022-24 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайдаар ажилласан туршлагатай. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Мөнгөнцогийн Ганхүлэгийн ажлын туршлага, төрийн албанд ажилласан мэдлэг, ур чадварыг харгалзан Соёл, спорт, залуучуудын дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүнд баярлалаа. Нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

Санал хураалт явуулъя.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалтад бэлдье.

Соёл, спорт, залуучуудын дэд хорооны даргад нэр дэвшигчийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Нийт гишүүдийн 89.5 хувиар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн тул Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

Дэд хороодын дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарыг Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийг Соёл, спорт, залуучуудын дэд хорооны даргаар сонгосугай.

Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тогтоолын төсөл нийт гишүүдийн 84.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

15.53 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР